

7

ӨРТГИЙН СИТЕМИЙГ УДИРДЛАГЫН ШИЙДВЭРТ ОНОВЧТОЙ АШИГЛАХ НЬ

Э.Цэцэгдэлгэр.

Оршил

Зах зээл дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниудын удирдлагууд эдийн засгийн хувьсан өөрчлөгдөх нөхцөл байдлыг мэдэрч, түүнд тохирсон богино хугацааны шийдвэрүүдийг ухаалгаар гаргах, компанийн үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах асуудал бизнесийн өмнө тулгарч байдаг. Үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын удирдлагын богино хугацааны шийдвэр гаргалтад нөлөөлдөг чухал мэдээллийн нэг нь зардал, өртгийн мэдээлэл байдаг. Өртөг, зардлын мэдээлэл нь оновчтой үнэн зөв байвал удирдлагын бодитой, үр дүнтэй шийдвэр гаргах үндэслэл болно. Манай улсад үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын зардлын бүртгэлийн тогтолцоонд сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц ахиц гарч байгаа боловч зардал, өртгийн мэдээллийн системийг удирдлагын шийдвэр гаргалтад оновчтой хэрэглэх шаардлага байсаар байна. Тиймээс компаниудад өөрийн үйлдвэрлэлийн онцлогт тохирсон өртгийн системийг нэвтрүүлэх хэрэгцээ зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Судалгааны зорилго

Зардлын бүртгэлийг удирдлагын шийдвэр гаргалттай холбох асуудалд ахиц гаргахад өөрийн хувь нэмрийг оруулах зорилгоор “Х” ХХК-ийн одоогийн хэрэглэж байгаа гүйцэтгэлийн бүрэн шингээлтийн зардлаар өртөг тооцох системийн өнөөгийн байдал, цаашид сайжруулах онол арга зүйн асуудлуудыг судлан стандарт хувьсах зардлаар өртөг тооцох системийг нэвтрүүлэх зорилго тавьсан. Тус компанийн бүтээгдэхүүний өртгийг стандарт хувьсах зардлаар тооцсоноор стандарт өртгийн системийг нэвтрүүлэх нөхцөл бүрдэх бөгөөд мөн өртөг тооцолтод гарах аливаа хүндрэлүүд шийдэгдэж, удирдлага богино хугацааны олон чухал шийдвэрүүдийг гаргах боломжтой болоход уг

судалгааны ач холбогдол оршиж байгаа юм. Уг судалгааныхаа хүрээнд өнөөдөр зах зээл дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа үйлдвэрлэл эрхэлдэг компаниудаас өртөг тооцох системийн хэрэглээ болон тэрхүү тооцсон өртгийн мэдээлэл нь удирдлагын урт, богино хугацааны шийдвэр гаргалт, төсөв, төлөвлөгөө боловсруулах зэрэгт хэрхэн оновчтой ашиглагдаж байгааг тодруулах зорилгоор тандалтын судалгааг авсан. Уг судалгааг 10 асуултаас бүрдсэн санал асуулгын хэлбэрээр авсан. Судалгаанд нийтдээ үйлдвэрлэл эрхэлдэг 25 компани хамрагдсан бөгөөд дийлэнх нь үндэсний гол үйлдвэрлэгч компаниуд, цөөн хэд нь жижиг компаниуд байв. Судалгаанд хамрагдсан томоохон компаниудаас заримыг дурьдвал: М-Си-Эс Кока Кола ХХК, АПУ ХК, Витафит ХХК, Чингис Шар Айраг ХХК, Говь ХК, Гоёо ХХК, Талх Чихэр ХХК, Өгөөж Чихэр Боов ХХК, Бамбууш ХХК зэрэг болно.


Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан нийт 25 компанийн 8 буюу 32% нь архи, ус, ундааны, 4 буюу 16% нь талх, нарийн боов, мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолууран бүтээгдэхүүний, 3 буюу 12% нь сүү, сүүн бүтээгдэхүүний, 2 буюу 8% нь бусад төрлийн үйлдвэрлэл эрхэлдэг компаниуд байв.

Хүснэгт № 1			
Д.д	Бүтээгдэхүүний төрөл	Тоо	Хувь
1	Архи, ус, ундаа	8	32
2	Талх, нарийн боов	4	16
3	Сүү, сүүн бүтээгдэхүүн	3	12
4	Мах, махан бүтээгдэхүүн	4	16
5	Ноос, ноолууран бүтээгдэхүүн	4	16
6	Бусад	2	8
	Нийт	25	100

Удирдлага урт болон богино хугацааны шийдвэр гаргахдаа ашигладаг мэдээллийн талаар тодруулахад:

Зураг № 1



Дээрх үр дүнг харахад хамгийн түгээмэл бөгөөд их ашиглагддаг мэдээлэлд санхүүгийн тайлан болон зах зээлийн үнэ ханшийн мэдээ багтжээ. Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын хувьд бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой урт, богино хугацааны шийдвэрүүдийг гаргахдаа өртгийн мэдээллийг нэгдүгээрт тавьдаг байна. (Хүснэгт № 2-с харах)

Хүснэгт № 2


	АНУ	Англи	Канад	Япон
Өртгийн мэдээлэл	1*	2	2	1
Төсөв, төлөвлөгөө	2	3	1	3
Үнийн мэдээлэл	3	1	3	2
Санхүүгийн тайлан	4	4	4	4

* Уг 1-4 гэсэн дугаарууд нь удирдлагын шийдвэр гаргалтанд дээрх мэдээллүүдийн хэрэглэгдэх эрэмбийг харуулсан болно.

Эндээс өртгийн мэдээлэл ямар чухал болох нь харагдаж байна. Харин манайд удирдлагын шийдвэр гаргалтанд зориулж өртөг, зардлын мэдээллийг бэлтгэж, ашиглахгүй байгаа нь харагдаж байна. Учир нь санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгдүгээрт тавьж, өртөг зардлын мэдээллийг дараагийн дугаарт авч үздэгтэй холбоотой гэж хэлж болно.


Бүтээгдэхүүний өртгөө тооцдог эсэхийг тодруулахад нийт 25 компаниас 23 буюу 92% нь ямар нэгэн байдлаар тооцдог гэж хариулсан.

Зураг № 2



Үгүй гэж хариулсан хоёр компани нь архины, оёдлын жижгэвтэр үйлдвэрүүд байв.

Зураг № 3




Онолын хувьд ажлын захиалгын аргыг тухайн бүтээгдэхүүний захиалгаар үйлдвэрлэдэг компаниудын хувьд ашигладаг ба дуусаагүй үйлдвэрлэл нь үлдэгдэлтэй гарч болдог. Судалгаанд оролцож, ажлын захиалгын аргыг хэрэглэдэг гэж хариулсан компаниуд нь нэг ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, дуусаагүй үйлдвэрлэл нь үлдэгдэлгүй гардаг боловч өртөг тооцохдоо өртгийн хуудас ашигладаг гэдгээрээ дээрх ажлын захиалгын аргыг хэрэглэдэг гэж хариулсан байдал ажиглагдаж байсан. Харин бусад гэж хариулсан компаниудын бүтээгдэхүүний өртөг тооцолтыг судалж үзэхэд ихэнх нь нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлын нийлбэрийг бүтээгдэхүүний тоо хэмжээнд харьцуулан тооцож байна.

Зураг № 4




Бүртгэлийн программ ашиглан өртгөө тооцдог гэж хариулсан компаниудын ихэнх нь ашиглаж буй программын өртгийн модуль учир дутагдалтай бөгөөд сайжруулах шаардлагатай байна гэсэн тайлбар өгч байсан. Тухайлбал: Өртөг тооцоолохдоо программаасаа MS Excel программ руу экспортлон холбогдох тооцооллыг хийж, буцаан өртгийн модульруу импортлох байдлаар өртгийн тайлан мэдээгээ гаргадаг байна.

Зураг № 5



Зарим компаниуд удирдлага шийдвэр гаргахдаа ашигладаг үндсэн мэдээлэл нь өртгийн мэдээлэл гэж хариулсан боловч өртгийн мэдээллийг ашиглан шинжилгээнүүдийг хийдэггүй байна. Харин шинэ зах зээлд нэвтрэх, шинэ бүтээгдэхүүн гаргах зэрэгт тухайн бүтээгдэхүүн ямар ашиг авчрахыг тооцоолох зорилгоор л тооцсон өртгийг тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэтэй зэрэгцүүлэн ашигладаг байна.

Зураг № 6



Бүтээгдэхүүний өртгөө тооцдог гэж хариулсан ихэнх компаниуд MS Excel программыг ашигладаг. Харин өртөг тооцох программын талаар ойлголт муутай байсан.

Зураг № 7



Судалгааны явцад өртгийг үнэн зөв тооцдог сайн программ байвал худалдах үнээс үл хамааран авч, ашиглах сонирхол их байгаа нь ажиглагдаж байв. Дээрхээс үзэхэд үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын өртөг тооцож буй байдал нь:

Нэгдүгээрт – Өртгийн талаар бага ойлголттой ба орлогын тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг зөв тооцдоггүй.

Хоёрдугаарт – Бүтээгдэхүүний нэгжийн өртгийг зөвхөн гүйцэтгэлээр гарсан зардлыг бүтээгдэхүүний тоо хэмжээнд харьцуулах замаар тооцдог.

Гуравдугаарт – Гүйцэтгэлийн бүрэн шингээлтийн зардлаар өртөг тооцдог гэсэн гурван түвшинд байна.

Гүйцэтгэлийн бүрэн шингээлтийн зардлаар өртөг тооцох үед гардаг сул талуудыг арилгах зорилгоор “Х” ХХК-ийн үйлдвэрлэдэг хийжүүлсэн ундаа, жүүс болон ус зэрэг бүтээгдэхүүнүүдийн өртгийг стандарт хувьсах зардлаар тооцох шаардлагатай гэж үзсэн. Тус компанийн бүтээгдэхүүний өртгийг стандарт хувьсах зардлаар тооцохын тулд компанийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ үйлдвэрлэлийн зардлыг судалж үзсэн. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхтэй холбогдон гарах материал болон үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын стандартыг тогтоохдоо өмнөх тайлант үеүдийн гүйцэтгэлээр гарсан үзүүлэлтүүдийн дунджаар авсан. Нэг литр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглагдах ус, болон нүүрсний дундаж хэмжээг тооцохдоо 2004-2010 он хүртэлх үйлдвэрлэлийн тоо мэдээг ашигласан ба энэ нь дараах байдалтай байна. (Хүснэгт № 3–с харах)

Хүснэгт № 3

Огноо	Үйлдвэрлэлийн хэмжээ	Цэвэр ус /тн/	Цэвэр ус /л/	Нүүрс /кг/	Нүүрс /кг/
Jan-04	6,000,000	6,450	1.0750	46,850	0.0078
Feb-04	3,000,000	3,313	1.1043	74,850	0.0250
Mar-04	4,500,000	4,667	1.0371	77,162	0.0171
Apr-04	4,000,000	3,927	0.9818	73,750	0.0184

May-04	2,500,000	2,335	0.9340	84,000	0.0336
Jun-04	6,000,000	6,242	1.0403	97,100	0.0162
Jul-04	8,000,000	8,155	1.0194	91,730	0.0115
Aug-04	8,600,000	8,720	1.0140	92,750	0.0108
Sep-04	7,000,000	7,729	1.1041	143,300	0.0205
Oct-04	6,000,000	6,431	1.0718	109,150	0.0182
Nov-04	5,000,000	4,581	0.9162	83,800	0.0168
Dec-04	6,000,000	5,950	0.9917	127,950	0.0213
:	:	:	:	:	:
Feb-10	3,500,000	3,562	1.0177	131,000	0.0374
1л бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах орцын дундаж хэмжээ			1.0097		0.0310

Нэг литр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглагдах ус болон нүүрсний дундаж хэмжээг дээрх байдлаар тооцсон ба бусад түүхий эдийн зарцуулалтыг технологийн дагуу стандарт норм хэмжээгээр тооцож нэгж бүтээгдэхүүний өртгийг гаргасан. Тухайлбал 1920л хийжүүлсэн ундаа үйлдвэрлэхэд 1 нэгж концентраци, 203.2 кг элсэн чихэр шаардагддаг гэсэн технологийн горимын дагуу 1л бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэдий хэмжээний концентраци болон элсэн чихэр орохыг тооцож бүтээгдэхүүн тус бүрийн нэгжийн нийт өртгийн стандартыг гаргасан болно. Хийжүүлсэн ундааг Пепси ундаагаар төлөөлүүлсэн ба бусад бүтээгдэхүүн тус бүрийн нэгжийн нийт өртгийн стандартыг тус бүр тооцсон. 1л Пепси ундаа үйлдвэрлэхэд зарцуулагдах норм дараах байдалтай бөгөөд үүнээс үндэслэн нэгжийн нийт өртгийн тооцоог хийв.

Хүснэгт № 4

Мөр №	Пепси	Гарцын хувь	Нэгжийн үнэ	Норм, 1л	Хэмжих нэгж
1	Концентраци	99.9%	10,000.00	0.00052	Нэгж
2	Элсэн чихэр	99.9%	2,000.00	0.11	Кг
3	Нүүрс хүчлийн хий	30.0%	5,000.00	0.007	
4	Ус	100.0%	2.00	* 1.0097	Литр
5	Цахилгаан	100.0%	79.80	100.00	втг/ц
6	Нүүрс	50.0%	100.00	** 0.0310	Кг
7	Хоолны давс /NaCl/		350.00	398.0	мг/л
8	Кальцийн гипохлорид /CaOCl ₂ /		10,000.00	105.0	мг/л
9	Кальцийн суурь /Ca(OH) ₂ /		10,000.00	45.0	мг/л
10	Төмрийн сульфат /Fe ₂ (SO ₄)/		10,000.00	25.0	мг/л
11	Натрийн шүлт /NaOH/		10,000.00	741.0	мг/л
12	Натрийн метабисульфит /Na ₂ S ₂ O ₃ /		10,000.00	21.0	мг/л
13	Савангын хөөс		10,000.00	697.0	мг/л

14	Лимоны хүчил		10,000.00	6.0	мг/л
15	Глюконат натри /С6Н11NaO7/		10,000.00	74.0	мг/л
16	Диво /Al/		10,000.00	2.0	мг/л
17	Диво /LE/		10,000.00	19.0	мг/л
18	Черниль /багцлагч/		100,000.00	0.18	төг/ундаа
19	Черниль /кодлогч/		100,000.00	0.03	төг/ундаа
20	Цэвэрлэгч		100,000.00	0.09	төг/ундаа
21	Бэх шингэрүүлэгч		100,000.00	0.10	төг/ундаа
22	Бөглөө	99.0%	9.09		

* Хүснэгт 3-с авав. 1л бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагдах усны хэмжээ.

** Хүснэгт 3-с авав. 1л бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагдах нүүрсний хэмжээ.

Дээрх хяналтын хуудсыг ашиглаж бүтээгдэхүүн тус бүрийн нэгжийн нийт өртгийг дараах байдлаар тооцох боломжтой болно.

үснэгт № 5

Мөр №	Ундаа	Пепси	
	Хэмжээ /литр/	0.25	
1	Концентраци	1.3034	1.3%
2	Элсэн чихэр	52.9775	52.0%
3	Нүүрс хүчлийн хий	30.9375	30.4%
4	Ус	0.0005	0.0%
5	Цахилгаан	1.9950	2.0%
6	Нүүрс	0.0016	0.0%
7	Химийн бүтээгдэхүүн	4.3723	4.3%
8	Код	0.2242	0.2%
9	Бөглөө	9.1818	9.0%
10	Савны хэвийн хорогдол	0.8000	0.8%
	Нэгжийн нийт өртөг	101.7938	100.0%

Нэгж бүтээгдэхүүний өртгийг хэрхэн тооцох аргачлалыг дэлгэрэнгүй байдлаар харуулбал.

1. Концентраци. 0.25л ундаанд орох концентрацийн өртгийн тооцоолол:

$$\text{Концентраци} = 10000 * 0.00052 * \frac{0.25}{99.9\%} = 1.3034 \text{ төгрөг}$$

10000 Нэгжийн өртөг /Хүснэгт 4, 1-р мөр/

0.00052 1л ундаанд зарцуулагдах норм /Хүснэгт 4, 1-р мөр/

0.25 Савлах хэмжээ, литрээр

99.9% Гарцын хувь /Хүснэгт 4, 1-р мөр/

1.3034 0.25л Пепси ундаанд зарцуулагдаж буй өртөг /Хүснэгт 5, 1-р мөр/

2. Элсэн чихэр. 0.25л ундаанд орох элсэн чихэрийн тооцоолол:

$$\text{Элсэн чихэр} = 2000 * 0.11 * \frac{0.25}{99.9\%} = 52.9775 \text{ төгрөг}$$

2000	Нэгжийн өртөг /Хүснэгт 4, 2-р мөр/
0.11	1л ундаанд зарцуулагдах норм /Хүснэгт 4, 2-р мөр/
52.9775	0.25л Пепси ундаанд зарцуулагдаж буй өртөг /Хүснэгт 5, 2-р мөр/

3. Нүүрс хүчлийн хий. 0.25л ундаанд зарцуулагдах нүүрс хүчлийн агууламжийн өртөг:

$$\text{Нүүрс хүчлийн хий} = 5000 * 0.007 * \frac{0.25}{30.0\%} = 30.9375 \text{ төгрөг}$$

5000	Нэгжийн өртөг /Хүснэгт 4, 3-р мөр/
0.007	1л ундаанд зарцуулагдах норм /Хүснэгт 4, 3-р мөр/
30.9375	0.25л Пепси ундаанд зарцуулагдаж буй өртөг /Хүснэгт 5, 3-р мөр/

4. Ус. 0.25л ундаанд зарцуулагдах усны тооцоолол:

$$U_c = \frac{2}{1000} * 1.0097 * \frac{0.25}{100.0\%} = 0.0005 \text{ төгрөг}$$

2	Нэгжийн өртөг /Хүснэгт 4, 4-р мөр/
1.0097	1л ундаанд зарцуулагдах норм /Хүснэгт 4, 4-р мөр/
0.0005	0.25л Пепси ундаанд зарцуулагдаж буй өртөг /Хүснэгт 5, 4-р мөр/

5. Цахилгаан. 0.25л ундаа үйлдвэрлэхэд зарцуулагдах цахилгааны зардал:

$$\text{Цахилгаан} = \frac{79.80}{1000} * 100 * \frac{0.25}{100.0\%} = 1.995 \text{ төгрөг}$$

79.80	Нэгжийн өртөг /Хүснэгт 4, 5-р мөр/
100	1л ундаанд зарцуулагдах норм /Хүснэгт 4, 5-р мөр/
1.995	0.25л Пепси ундаанд зарцуулагдаж буй өртөг /Хүснэгт 5, 5-р мөр/

6. Нүүрс. 0.25л ундаанд зарцуулагдах нүүрсний өртөг:

$$\text{Нүүрс} = \frac{100}{1000} * 0.0310 * \frac{0.25}{50.0\%} = 0.0016 \text{ төгрөг}$$

100	Нэгжийн өртөг /Хүснэгт 4, 6-р мөр/
0.0310	1л ундаанд зарцуулагдах норм /Хүснэгт 4, 6-р мөр/

0.0016 0.25л Пепси ундаанд зарцуулагдаж буй өртөг /Хүснэгт 5, 6-р мөр/

7. Химийн бүтээгдэхүүн. 0.25л ундаанд зарцуулагдах химийн бүтээгдэхүүний өртөг:

$$\text{Химийн бүтээгдэхүүн} = \sum_{i=7}^{17} \text{Нэгжийн үнэ } i * \text{Норм } i = 4.3723 \text{ төгрөг}$$

i Хүснэгт 4-н мөрийн дугаар /7-17-р мөр/
Нэгжийн үнэ *i* Химийн бүтээгдэхүүн тус бүрийн нэгжийн үнэ /Хүснэгт 4, 7-17-р мөр/
Норм *i* 1л ундаанд зарцуулагдах норм /Хүснэгт 4, 7-17-р мөр/
4.3723 0.25л Пепси ундаанд зарцуулагдаж буй өртөг /Хүснэгт 5, 7-р мөр/

8. Код. Нэг ширхэг бүтээгдэхүүнийг кодлох зардлын тооцоо:

$$\text{Код} = \sum_{i=18}^{21} \text{Нэгжийн үнэ } i * \text{Норм } i = 0.2242 \text{ төгрөг}$$

i Хүснэгт 4-н мөрийн дугаар /18-21-р мөр/
Нэгжийн үнэ *i* Кодлоход зарцуулагдах бүтээгдэхүүн тус бүрийн нэгжийн үнэ /Хүснэгт 4, 18-21-р мөр/
Норм *i* Нэг ширхэг ундаанд зарцуулагдах норм /Хүснэгт 4, 18-21-р мөр/
0.2242 0.25л Пепси ундаанд зарцуулагдаж буй өртөг /Хүснэгт 5, 8-р мөр/

9. Бөглөө. Нэг сав ундааны бөглөөний өртөг:

$$\text{Бөглөө} = \frac{9.09}{99.0\%} = 9.1818 \text{ төгрөг}$$

9.09 Нэг ширхэг бөглөөний өртөг /Хүснэгт 4, 22-р мөр/
99% Гарцын хувь /Хүснэгт 4, 22-р мөр/
9.1818 Нэг ширхэг ундаанд зарцуулагдах бөглөөний өртөг /Хүснэгт 5, 9-р мөр/

10. Хуванцар савны хэвийн хорогдол. Сард дунджаар бүтээгдэхүүнийг савлахад ашиглаж буй хуванцар савны 1% нь хорогддог. Иймээс нэг ширхэг хуванцар савны өртөг 80 төгрөгийн 1% болох 0.80 төгрөгийг нэг ширхэг ундааны өртөгт шингээнэ.

“Х” ХХК-ийн үйлдвэрлэж буй хийжүүлсэн ундааны өртгийг дээрх байдлаар тооцоход 0.25л-н хэмжээтэй Пепси ундааны нэгжийн нийт өртөг нь **101.7938** төгрөг (Хүснэгт 5, Нэгжийн нийт өртөг) болж байна. Мөн бусад төрлийн

савлагаатай ундаа болон жүүсний өртгийг төрөл тус бүрээр тооцож үзсэн болно.

Дүгнэлт

Орчин үед өндөр хөгжилтэй орнуудад үйлдвэрлэлийн арга техник, технологийн өөрчлөлттэй холбоотойгоор үйлдэлд суурилан өртөг тооцох систем, зорилтот өртгийн систем, кайзен өртгийн систем зэрэг өртгийн системүүдийг нэвтрүүлэн хэрэглэж байна. Ингэснээр удирдлагын урт болон богино хугацааны олон шийдвэрүүдийг үндэслэлтэй гаргах, улмаар эдийн засгийн ашгийг хэмжих боломж бүрдэж байгаа юм.

Судалгааны объект болох “Х” ХХК нь одоогийн байдлаар гүйцэтгэлийн бүрэн шингээлтийн зардлаар өртөг тооцох системийг хэрэглэдэг. Энэхүү өртгийн системийн үед бүтээгдэхүүний өртгийг тооцох ажиллагаа хялбар байдаг боловч өртгийг бүрдүүлэгч ихэнх шууд бус зардлууд хичнээн хэмжээгээр тухайн бүтээгдэхүүний өртөгт шингэх нь тайлант хугацааны эцэс хүртэл тодорхойлогдохгүй, гүйцэтгэлээр гарсан зардлуудыг бүгдийг нь бүтээгдэхүүний өртөгт шингээдэг учраас зардлын хэтрэлт, хэмнэлтэд тавих хяналт муу, мөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явагдаагүй байсан ч тогтмол зардлуудыг өртөгт оруулдаг, зэрэг сул талуудтай. Эдгээр сул талуудыг багасгахын тулд тус компанид стандарт хувьсах зардлаар өртөг тооцох системийг нэвтрүүлсэн бөгөөд холбогдох тооцооллуудыг хийсэн. Өртгийн тооцооллыг хийхэд 2004-2010 онуудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээллийг ашигласан. Үйлдвэрлэлийн технологитой холбоотой мэдээллийг тухайн үйлдвэрийн технологичдоос, түүхий эд тус бүрийн нэгжийн үнийг 2010 оны эхний хоёр улирлын үнийн дунджаар авсан болно. Тус компанийн үйлдвэрлэлд стандарт хувьсах зардлаар өртөг тооцох системийг нэвтрүүлснээр дараах давуу талууд бий болж байна. Үүнд:

- Зардлын хэтрэлт, хэмнэлтэд тавих хяналт сайжирна.
- Үйл ажиллагааны цэвэр ашиг үнэн зөв илэрхийлэгдэнэ.
- Стандарт хувьсах зардлаар тооцсон өртгийн мэдээллийг ашиглан удирдлагын шийдвэр гаргалтад ашиглагдах олон шинжилгээнүүдийг хийх боломж бүрдэнэ. Тухайлбал:
 1. Бүтээгдэхүүний тусгай захиалгыг биелүүлэх эсэх тухай шийдвэр
 2. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх тухай шийдвэр
 3. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шугамыг нэмэгдүүлэх эсэх тухай шийдвэр
 4. Өөрөө үйлдвэрлэх эсвэл гаднаас импортлох эсэх тухай шийдвэр
 5. Нэмэлт боловсруулалт хийх эсэх тухай шийдвэр
 6. Хязгаарлагдмал нөөцийн ашиглалттай холбоотой шийдвэрүүдийг гаргах боломжтой болно.

Энэхүү стандарт хувьсах зардлаар өртөг тооцох системийг нэвтрүүлэхийн тулд боловсруулсан стандарт өртгийн загварыг “Х” ХХК-тай ижил төстэй буюу цэвэр ус, хийжүүлсэн ундаа зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг газрууд шууд ашиглах боломжтой болж байгаад судалгааны ажлын ач холбогдол оршиж байгаа юм.

Мөн стандарт хувьсах зардлаар өртөг тооцох системийг үйлдвэрлэлийн онцлогт тохируулан программчлах шаардлагатай байна. Учир нь Интерактив компанийн гаргасан бүртгэлийн программын өртөг тооцох модуль стандарт зардлаар өртөг тооцоход учир дутагдалтай байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байсан. Ихэнх компаниуд өртөг тооцоход MS Excel программыг ашигладаг байна. Ийм учраас одоо ашиглаж байгаа бүртгэлийн программд сайжруулалт хийх эсвэл өртөг тооцох тусгай программ загварчилж болох юм.

Ном зүй.

1. Ц.Баянмөнх, Б.Сайнжаргал (ред) 2005, *Зардал, удирдлагын нягтлан бодох бүртгэл*, I дэвтэр, Өнгөт хэвлэл ХХК, Улаанбаатар.
2. Ц.Баянмөнх, Б.Сайнжаргал (ред) 2009, *Зардал, удирдлагын нягтлан бодох бүртгэл*, II дэвтэр, Мастер Принт ХХК, Улаанбаатар.
3. Д.Моломжамц, 1999, *Удирдлагын бүртгэл*, Улаанбаатар.
4. Т.Жааваа, 2002, *Санхүү, өртөг, удирдлагын бүртгэлийн төлөвшил, шинэтгэл дэх нэн тулгамдсан асуудлууд*, Улаанбаатар.
5. С.Өлзийбат, 1996, *Зардлын нягтлан бодох бүртгэл*, Улаанбаатар.
6. Н.Тунгалаг, 2004, *Зардал-Удирдлагын бүртгэл: шинжилгээ-загварчлал*, Хөх судар принтинг ХХК, Улаанбаатар.
7. Garrison, Noreen, Brewer, 2006, *Managerial accounting*, The McGraw-Hill Companies, Inc, USA.
8. UNDP, 1999, *Зардал ба удирдлагын бүртгэлийн гарын авлага*, Мөнхийн үсэг ХХК, Улаанбаатар.
9. Usry.M.Ph, Hummer.L.H, 2000, *Зардлын нягтлан бодох бүртгэл, төлөвлөлт ба хяналт*,
10. Albert L.Lederer, Rajesh Mirani, 2006, *Information System cost estimating*, <http://www.jstor.org/stable/248774>.
11. Cost accounting, http://en.wikipedia.org/wiki/Cost_accounting
12. “Х” ХХК-ийн 2004-2010 онуудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээлэл.